



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/1357

Улаанбаатар хот

### Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3.2 дахь заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03/03 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2018 оны 62 дугаар, 2022 оны 223 дугаар тогтоол, Нийслэлийн Онцгой комиссын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын 2018 оны 62 дугаар, 2022 оны 223 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Налайх дүүргийг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал"-ын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Зарим дүүргийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.

2.1.сайжруулсан шахмал түлшний баруун, зүүн бүсийн үйлдвэр хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч, түлшний чанар, стандарт, хадгалалтын горимыг баримталж ажиллахыг "Таван толгой түлш" ХХК (Ц.Даваацэрэн)-д;

2.2.нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдийн сайжруулсан түлшний хэрэглээг бодит болгох зорилгоор "Нэг өрх-Нэг карт" зарчмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц.Ганболд), "Таван толгой түлш" ХХК (Ц.Даваацэрэн)-д;

2.3.сайжруулсан шахмал түлш түгээх цэг, байршил, цагийн хуваарьтай холбоотой мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагыг оролцуулан зохион байгуулахыг дүүргүүдийн Засаг дарга нарт болон Нийслэлийн Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т;

2.4.сайжруулсан шахмал түлшний чанар, стандартад тогтмол хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (С.Даваасүрэн), Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц.Ганболд)-т;

2.5.сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа тээврийн компаниудын машин, техникийн бэлэн байдал, тоо, хүчин чадлыг нарийвчлан тодорхойлж, айл өрхүүдийг сайжруулсан түлшээр тасалдуулахгүй хангах арга хэмжээ авч ажиллахыг "Таван толгой түлш" ХХК (Ц.Даваацэрэн), Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц.Ганболд)-т;

111020006272

2.6. нийслэлийн агаар, орчныг бууруулах, сайжруулсан шахмал түлшний ханган нийлүүлэлттэй холбоотой асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ тухай бүр авч ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагуудад.

3. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулагдсан "Шуурхай штаб", харьяа хэлтэс, алба, хороодын үйл ажиллагааг Нийслэлийн Онцгой комиссын шийдвэрт нийцүүлэн, нэгдсэн удирдлагаар хангаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч, биелэлтийг 7 хоног бүр танилцуулж байхыг дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Авто тээврийн шалган бүртгэх товчоо, маршрутын бус замаар Улаанбаатар хот руу түүхий нүүрс нэвтрүүлэхгүй, сайжруулсан шахмал түлш гаргахгүй байхад онцгой анхаарч, хяналт шалгалтыг тогтмол явуулан, хариуцлагыг чангатгаж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (С. Даваасүрэн), Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р. Отгонжаргал), Нийслэлийн Онцгой байдлын газар (А. Дашням), Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц. Ганболд) болон дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Сайжруулсан шахмал түлшний ханган нийлүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг тухай бүр шийдвэрлэж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н. Наранбаатар) болон дүүргүүдийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

6. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З. Төмөртөмөөд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д. СУМЬЯАБАЗАР

